



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

Гарчиг

НЭГ. Ерөнхий зүйл

ХОЁР. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

ГУРАВ. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

ДӨРӨВ. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.2.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.4.“Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ТАВ. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

5.1. Баримтжуулалт

5.2. Дүгнэлт

5.3. Зөвлөмж

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн /цаашид “ХТТХ” гэх/ 12.1.2 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсны үндсэн дээр хуулийн төслийг шинэчлэн боловсруулах хувилбарыг сонгон авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хамтран баталсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3 дахь заалтад заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээг боловсрууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээг дараах үе шаттайгаар хийлээ.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 159 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан доорх 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал”: Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж чадах эсэх; хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх; хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тооцох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Ойлгомжтой байдал”: Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой байгаа эсэх; хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх; агуулга, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгомжтой эсэхийг тогтоох зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”: Хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн зохицуулалтад шууд хамаарах этгээд уг зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгаж үр нөлөөний үнэлгээг хийх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Харилцан уялдаа”: Хуулийн төслийн зүйлүүд бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа, эсхүл зөрчилдөж байгаа эсэхийг болон хүний эрхэд нөлөөлөх байдлыг нь Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлэх шаардлагатай гэж үзэж тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх, хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх заалтад заасан аргачлалын 5 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хуулийг хэрэгжүүлэх байгууллага /Монгол Улсын Засгийн газар/, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, ажилтан/ хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-д заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд дээрх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ.

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль анх 2001 онд батлагдаж, 2011 онд шинэчилсэн найруулга хийгдсэн. Уг хууль нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн. Хууль нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, түүний зохион байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарцуулалт, төсөв, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналттай холбоотой харилцааг тусгасан 7 бүлэг, 34 зүйлтэй.

Монгол Улс 2016 онд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 181 дүгээр конвенцод тус тус нэгдсэн тул Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжоо уг конвенцуудтай нийцүүлэх үүрэг олон улсад хүлээсэн.

Сүүлийн жилүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), Ахмад настны тухай хууль (2017), Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017), Хөдөлмөрийн тухай хууль (2021 он), Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (2021), Нийгмийн даатгалын багц хууль (2023 он), Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023) зэрэг хуулиуд шинэчлэгдсэн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болсон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу урьдчилан тандан судалсны үндсэн дээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах дараах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байна. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг анх 2001 онд анхлан баталж, 2011 онд шинэчлэн найруулсан. Улмаар 2011, 2012, 2014, 2015, 2016, 2017, 2021, 2022, 2023, 2024 онд нийт 20 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Гэвч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан¹ болон холбогдох судалгааны тайланд² уг хууль хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зорилтоо хангалттай биелүүлээгүй гэж дүгнэсэн. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн 2011 онд ажиллах хүчний оролцооны түвшин 62.5 хувь, ажилгүйдлийн түвшин 7.7 хувь байсан бол 2024 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь, ажилгүйдлийн түвшин 5.9 хувьтай байна. Мөн эдгээр үзүүлэлтүүд эмэгтэйчүүд, залуучууд зэрэг зарим хүн амын бүлэг болон бүс

¹ Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг гүйцэтгэсэн тухай тайлан, УБ., 2024 он

² Н.Монголмаа. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлан /2016/, Н.Аюуш. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн агуулга, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж /2015/, Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээний тайлан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж /2015/, Дэлхийн банк судалгааны тайлан. Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний үнэлгээ /2020/, Дэлхийн банк. Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ, Удирдлагын академи. Монгол Улсын уул уурхайн бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ /2020/, Европын Холбоо. Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн тайлан /2017/, Дэлхийн банк. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ” нэгтгэсэн тайлан /2022/.

нутагт дордож хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдэд дорвитой эерэг өөрчлөлт гараагүй нь дээрх дүгнэлтийг бататгаж байна.

Мөн хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэлтийн орчин үеийн чиг хандлагууд болох цахим шилжилтийн нөлөөлөл, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөрийн харилцааны шинэ хэлбэрүүд, хүн амын насжилтыг угтсан ахимаг болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, асрахуйн эдийн засгийг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хөдөлмөрт шилжүүлэх зэрэг асуудлаарх хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалттай бус байна.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн явцад “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний бүхий л үе шатанд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хүн амын зорилтот бүлгүүдийг хамруулах, оролцоог хангах зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үүссэн.

Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан болон хөдөлмөрийн зах зээлд шинээр, дахин нэвтрэхэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нэн шаардлагатай байгаа иргэдийн онцлог, хэрэгцээнд тохирсон харилцан уялдаа бүхий хөдөлмөр, нийгмийн ажлын үйлчилгээ, арга хэмжээ дутмаг байна.

“Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжийг уялдуулах, нийгмийн халамжид хамрагддаг хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэхэд үе шаттайгаар дэмжих, халамж авагчаас аажмаар хөдөлмөр эрхлэгч болгох үйл ажиллагаа хүртээмжгүй байна. Өнгөрсөн хугацаанд “халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлснээр хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдах хүний тоо буурсан, “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-т хамрагдсан зорилтот өрхүүдийн 80 гаруй хувь нь тогтмол орлоготой болж, тогтвортой амьжиргаанд хүрэх боломж бүрдсэн зэрэг бодлогын үр дүн гарсан.

Цаашид “халамжаас хөдөлмөрт” бодлогыг кейс менежментэд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэлбэрээр илүү хүртээмжтэй үзүүлэх нь зүйтэй байна.

3.Хөдөлмөр эрхлэлт, боловсролын бодлогын уялдаа холбоо хангалтгүйн улмаас хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүссэн, ялангуяа мэргэжил, ур чадварын зөрүүтэй байдлаар түлхүү илэрч байгаад анхаарах шаардлагатай байна. Тухайлбал: нийт ажиллагсдын 53.0 хувь нь мэргэжлийн зөрүүтэй ажил эрхэлдэг, улмаар тэдний орлого эзэмшсэн мэргэжлээр ажиллаж байгаа хүнээс 10 гаруй хувийн зөрүүтэй байгаа нь судлагдсан. Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг мөшгөн судлахад 15.7 хувь нь эзэмшсэн мэргэжилд маш тохиромжтой, 55.7 хувь нь тохиромжтой, 28.6 хувь нь тохирдоггүй буюу мэргэжлийн бус ажил эрхэлдэг болох нь тодорхойлогдсон байна.

4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг 2012-2017 онуудад жил бүр, 2018 оноос 2 жил тутам шинэчлэн баталж ирсэн. Эдгээр нь ихэвчлэн 1-2 жилийн мөчлөгтэй, хөтөлбөрийн тоо, хэрэгжүүлэх удирдамж жил бүр өөрчлөгддөг, зорилтот бүлгээ хэт нарийвчлан тодорхойлж, хүрээг хязгаарласнаас шалтгаалж аж ахуй эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг үр дүн багатай, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлүүлэх үйл явц хүндрэл бэрхшээлтэй, бизнесийн гараа, хөгжлийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг, зээлийн хэмжээ хангалтгүй байгаа зэрэг асуудлууд тулгамдсан шинжтэй байна.

5.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалттай бус, үйлчилгээ үзүүлдэг албан хаагчдын захиргааны ажлын ачаалал их, орон тоо, бүтэц зохион байгуулалт оновчгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг “төрийн захиргааны ажилтанд суурилсан үйлчилгээ”-ээс “үйлчлүүлэгчид суурилсан кейс менежментийн үйлчилгээ”-нд шилжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйлчилгээний шаардлага, стандартыг тогтоох эрх зүйн орчин сул байна.

6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний бүхий л үе шатанд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, дүн шинжилгээний ажлын үр дүнг ашиглах, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

4.2.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх заалтад заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага”-д заасан шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Хүснэгт 2

Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага		
1	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
2	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
3	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
4	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Уг шаардлагыг хангасан.
5	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Уг шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага		
6	Хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийг хэл зүйн, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл, бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар байна	Уг шаардлагыг хангасан.
7	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байна	Уг шаардлагыг хангасан.
Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга ажиллагаа		
8	1.Нэр томьёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох 3.Товчлол хийх 4.Ишлэл хийх	Уг шаардлагыг хангасан.

Хуулийн төслийн эх бичвэрийг компьютерт боловсруулахад тавих шаардлага		
9	Эх бичвэрийг компьютерт боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичиг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний Зөвлөлийн 2021 оны “Баримт бичгийн стандарт MNS 5140-1:2021”-ыг баримталсан болно.

4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх субъект нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, болон хуульд заасан бодлогын арга хэмжээний үр шимийг хүртэгсэд юм.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээд хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгав. Ингэхдээ дараах асуултад хариулахыг эрмэлзсэн.Үүнд:

- 1.Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломж хэр байгаа;
- 2.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
- 3.Хэрэгжүүлэх субъект байгаа бол түүнд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ бий эсэх зэрэг асуудлын хүрээнд үр нөлөөг үнэлсэн болно.

Хүснэгт 3

№	Хэрэгжүүлэх боломж, субъект, нөөц бололцоо	Сонгосон зүйл, заалт
1	Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага /цаашид “ОУХБ” гэх/-д 1968 онд гишүүнээр элссэнээсээ хойш энэ байгууллагаас баталсан Олон Улсын 21 конвенц, үүний дотор суурь 9, засаглалын буюу тэргүүлэх ач холбогдолтой 2, техникийн шинжтэй 10 конвенцод нэгдэн орж хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байна. Нэгдэн орсон Олон Улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх асуудалд цогц байдлаар хандах шаардлага үүссэн тул 2016 онд “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргаж, улмаар мөн оноос эхлэн Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг ерөнхий чиг үүргийн яам болгосон. Ингэснээр тус яам нь чиглэлийн яамны хувьд гүйцэтгэж байсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүргээсээ гадна хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг хөгжлийн бодлогын үндэс болгох ерөнхий чиг үүрэг хэрэгжүүлэх хариуцлага хүлээжээ. Гэвч дээр дурдсан бодлогыг 2021 онд хүчингүй болгож, 2023 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг буцаан чиглэлийн яамдын бүтцэд хамааруулсан байна.	Хуулийн төслийн 6-8 дугаар зүйл.
2	Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-т заасны дагуу олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөл нь “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах” үйлчилгээ бөгөөд улсын хэмжээнд 8000 орчим иргэн энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа ч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ, бодлого, хөтөлбөрүүдтэй уялдаагүй учраас тэдний хөдөлмөр эрхлэлтэд бодит дэмжлэг туслалцаа болж чадахгүй байна. Энэ нь халамж	Хуулийн төслийн 4.1.8 11.2.3 дахь заалт.

	хүртэгч иргэдийг ядуурлаас гаргах бодлогын дэмжлэг дутагдаж байгааг харуулж байгаагаас гадна тэднийг халамжаас хамааралтай болгох, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг нь бууруулах сөрөг үр дагаврыг бий болгож байна.	
3	Улсын хэмжээнд сүүлийн дөрвөн жилийн дунджаар жилд 41463 хүнийг ажилд зуучилсан байна. Үүнээс хөдөлмөр эрхлэлтийн газар, хэлтэс, албанаас зуучилсан хүний дундаж тоо 39489, хувийн биржүүдээс зуучилсан хүний дундаж тоо 1974 байна. Төрийн захиргааны 31 байгууллагын тоонд хуваахад нэг байгууллага жилд дунджаар 1274 хүн ажилд зуучилсан байна. Хувийн 21 бирж мэдээ ирүүлснээс үзэхэд тэд жилд дунджаар 94 хүнийг ажилд зуучилжээ.	Хуулийн төслийн 15-25 дугаар зүйл.
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах зорилтот бүлэг нь хэт өргөн тодорхойлогдсон, хэрэгжүүлж буй арга барил зэргээс шалтгаалж санхүүгийн дэмжлэг нь халамжийн буцалтгүй тусламж мэт тооцогддог, хөнгөлөлттэй зээл олгох үйл явц тодорхой хүндрэл бэрхшээлтэй, бизнесийн гараа, хөгжлийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг болон зээлийн хэмжээ хангалтгүй гэх зэрэг хүндрэл байнга гардаг.	Хуулийн төслийн 27-47 дугаар зүйл.
5	Халамжийн хэлтэс, хөдөлмөрийн хэлтэс гэсэн хоёр хэлтэс 2016 онд нэгдэхэд Чингэлтэй дүүргийн тухайд гэхэд хөдөлмөрийн хэлтэс нь 29 албан хаагчтай, халамжийнх нь 56 албан хаагчтайгаар нэгдсэн атал дөнгөж 57 албан хаагчтай болгосон. Үүний дотор хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс 7-хон албан хаагчтай болсон бөгөөд ачаалал тэнцвэргүй, ХЭДТХ-ийг хэрэгжүүлэхэд асар хүндрэлтэй болсон.	Хуулийн төслийн 64 дүгээр зүйл.
6	Хороон дээр ажилладаг албан хаагчдын хувьд 5000 иргэн дутамд 1 албан хаагч ажиллах зохион байгуулалттай байдаг. Гэтэл одоо Чингэлтэй дүүрэгт гэхэд 12, 7,16, 17,18 хороод бүгд 10 мянга гаруй хүнтэй, 3 албан хаагч ажиллах ёстой байтал дандаа 1 албан хаагч ажиллаж байгаа тул ачаалал маш өндөр тиймээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүргийг нийгмийн халамжийн үйлчилгээнээс салгаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Учир нь хороон дээр албан хаагчид зөвхөн халамжийн ажил хийж байна. Өдөрт 100-300 хүн орж ирдэг, ажилтан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажил хийх ямар ч бодит боломжгүй суудаг.	Хуулийн төслийн 8.6, 8.7 дахь хэсэг.
7	ХЭДС-аас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй.	Хуулийн төслийн 75.1.2 дахь заалт.
8	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл нь хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллээр хязгаарлагдсан, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангалтгүй.	Хуулийн төслийн 48 дугаар зүйл, 54.2 дахь хэсэг, 55 дугаар зүйл.

4.4. “Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон бусад холбогдох хуульд нийцсэн эсэхийг шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-г заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

Асуулт 1:Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм.

Асуулт 2. Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх?

Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэж хуульд заасан ерөнхий байдлаар тодорхойлсон.

Асуулт 3. Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт тусгагдсан нэр томъёо нь хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа болно.

Асуулт 4: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн зүйл, заалттай нийцэж байгаа эсэх?

Хариулт: Тийм

Дүн шинжилгээ: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо зөрчилгүй байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай зөрчилдөөгүй болно.

Асуулт 5: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан эсэх?

Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо давхардаагүй байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай давхардаагүй байна.

Асуулт 6: Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх?
Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн тавдугаар бүлгээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөр асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, эрх, үүрэг болон бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллаг, Засаг дарга нарын эрх, үүргийг, мөн хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаан дахь иргэний эрх, үүрэг, оролцоо, нийгмийн түншүүдийн үүрэг, чиг үүргийг тус тус тодорхой зааж өгсөн.

Асуулт 7. Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?
Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслөөр зохицуулах шаардлагатай бүх харилцааг зохицуулсан бөгөөд орхигдуулсан зохицуулалт байхгүй гэж үзэж байна.

Асуулт 8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;
Хариулт: Үгүй.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 32 дугаар зүйлээр Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, 33 дугаар зүйлээр Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, 34 дүгээр зүйлээр Хөдөлмөрийн судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын, 35 дугаар зүйлээр Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын, 36, 37 дугаар зүйлээр бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүргийг тус тус тодорхой зааж өгсөн болно.

Асуулт 9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;
Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 38, 39 дүгээр зүйлд Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын чиг үүрэг, тэдгээрийн бүртгэл, үйлчилгээний төлбөр, санхүүжилтийн талаар, 40 дүгээр зүйлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгүүлэх талаар тус тус тодорхой заасан байна.

Асуулт 10: Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх?
Хариулт: Үгүй.

Асуулт 11: Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх?

Хариулт: Үгүй. /Хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн зохицуулалт байхгүй болно./

Асуулт 12: Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 13: Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?

Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд үл ялгаварлах, жендерийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлахаар заасан ба хуулийн төсөлд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодлоор ялгаварлаагүй болно.

Асуулт 14: Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 15: Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?

Хариулт: Үгүй.

Асуулт 16: Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх?

Хариулт: Тийм.

Дүн шинжилгээ: Хуулийн төслийн 7 дугаар бүлгийн 45 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэх асуудлыг тодорхой тусгасан.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг ашиглалаа.

1.Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон бусад холбогдох хуулиуд;

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд гарсан дүрэм, журам болон бусад холбогдох тогтоол, шийдвэрүүд;

3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу хийсэн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;

4.Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 181 дүгээр конвенцод хийсэн харьцуулалтын үнэлгээний тайлан;

5.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэдээллийн и-жоб цахим системд бүртгэгдсэн мэдээлэл;

6.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гарсан бусад судалгаа, тайлан;

7.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;

8.Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан хуулийн төсөл, танилцуулга.

5.2. Дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлд нийцэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх хэсэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын хоёрдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулахад тавих нийтлэг шаардлага”-д заасныг бүрэн хангаж байна гэж үзэж байна.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн харилцан уялдааг хангах шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3-т заасан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан 16 асуултад хариулах байдлаар шалгахад “харилцан уялдаа”-г бүрэн хангаж байна гэж үзсэн.

5.3. Зөвлөмж

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар зохицуулж байсан харилцааг өргөжүүлж, нийгэм, эдийн засагт гарч байгаа шинэ өөрчлөлт, чиг хандлагатай уялдуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлж, батлагдсаны дараа хуулийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинээр батлуулах шаардлага үүсэж байна.

_____оОо_____